



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн  
хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн  
аудитын тайлан



2018 он

АУДИТЫН ТАЙЛАНГ  
**БЭЛТГЭСЭН:** Булган  
 аялаг дахь Төрийн  
 аудитын газар

Дарга, тэргүүлэх  
 аудитор  
 Д.Анхбаяр

Аудитын менежер  
 Ж.Энхцододол

Ахлах аудитор  
 Г.Намчинсүрэн  
 Аудитор  
 З.Ганбаатар

2018 оны 11 дүгээр ىаад

Óã òàéëàíá aéìag дахь  
 Төрийн àòäèòùí ãàçðààñ  
 àâ÷ չçíý չ:

Àóäèòùí òàéëàíòàé  
 õîéáïïòíé àñóóäèàò íýìæ  
 òiäðóóëàò, àñóóø  
 ëàâèàò چéë áàéâàë  
 70342495, 70342716  
 óòàñààð ôàéñ:70342580  
 äóñààðààð òàðèëöàíá óó

ÓАЯГ:

Áóëñàí ñòì 5-ð áàã  
 Нутгийн удирдлагын  
 ордон  
<sup>a</sup>ðoo 1 401 őññ  
 Bulgan@audit.gov.mn

<i>Төвчилсон үгийн тайлбар.....</i>	<i>2</i>
<i>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга, зүй, шалгуур зүүлэлт.....</i>	<i>3-4</i>
<i>Бүлэг 1. ОНХС-ийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийн төлөвлөлт, бүрлүүлэлт холбогдох хууль дүрэмд нийцэж байгаа боловч сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, зарцуулахад тавих хяналт сул байна.....</i>	<i>5-13</i>
<i>Бүлэг 2. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийн төлөвлөлтийг холбогдох журамд заасны даагуу бүрэн төлөвлөөгүй, сангийн хөрөнгөөс зээл олгоходоо холбогдох журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй төслийг сонгон шалгаруудаг, зээлийн эргэн төлөлтийн хуваарийн даагуу зээлийг хугацаандaa төлдөггүй нийтлэг зөрчил байна.....</i>	<i>13-20</i>
<i>Бүлэг 3. Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт нийт 91.6 хувийн гүйцэтгэлтэй байна.....</i>	<i>20</i>
<i>Дүгнэлт.....</i>	<i>21</i>

<i>Зөвлөмж.....</i>	<i>22</i>
---------------------	-----------

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэдсэн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын алба
СЯ	Сангийн яам
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны “Аудитын сэдэв батлах тухай” 03 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийллээ.

### Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийллээ.  
Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх;

### Аудитын хамрах хүрээ:

Аудитад Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2017 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, мөн Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, хяналт, тайлагналыг аймаг, 8 сум, 1 тосгоны ИТХ, ЗДТГ, СТСХ, ЭЗТХ, Баг, хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгалаа.

### Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн дээрх сангидын хөрөнгийн зарцуулалтад хийх аудитын эрсдлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үзлээ.

### Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан Сангийн яам, Хүнс, хөдөө аж аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам,

аймаг нийслэ, сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн болон холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

### **Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- МУ-ын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам;

### **Ерөнхий мэдээлэл:**

**Аймгийн ОНХС:** Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлуудыг аймгийн ИТХ-ын 2016 оны 3 дугаар хуралдааны 03/03 тоот тогтоолын хавсралтаар хөрөнгө оруулалтын 4 ажилд 668.0, тоног төхөөрөмжийн 2 ажилд 55.0, хөтөлбөр төсөл арга хэмжээний 4 ажилд 238.0, нийт 961.0 сая төгрөгийг батлуулж, 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн IV/04 тоот тогтоолын хавсралтаар хөрөнгө оруулалтын 6 ажилд 788.8, тоног төхөөрөмжийн 2 ажилд 55.0, хөтөлбөр төслийн 4 ажилд 238.0 буюу нийт 1081.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тодотгол хийгдэн баталж өмнөх тогтоолоос хөрөнгө оруулалтын 2 ажлын 120.8 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэгдүүлж нийт 12 ажил хийгдэхээр баталсан байна.

**Сумдын ОНХС:** ОНХС-гаас Булган аймгийн 16 суманд 2017 онд 567.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж 553.9 сая төгрөг санхүүжилт олгосон байна.

ОНХС-гаас олгогдох санхүүжилтийн дагуу аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05 -ны өдрийн хуралдааны 03/03 тоот тогтоолоор 2017 онд сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүгийн дэмжлэгт 567.5 сая олгохоор баталсныг аймгийн ИТХ төсвийг 1 удаа тодотгон баталсан, аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06/01 тоот тогтоолоор сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүгийн дэмжлэгийг 553.9 сая төгрөг олгохоор тодотгожээ.

Булган аймаг дахь Төрийн  
Аудитын газар

Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт,  
зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль  
тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан уу?

### Бүлэг I

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг хууль, журамд заасны дагуу төлөвлөн хуваарилсан байна. ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд эрх бүхий байгууллага хяналт тавьж, дүн шинжилгээ хийгээгүй байна.

#### 1.1.1. Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох шилжүүлгийг Сангийн сайдын баталсан аргачлалын дагуу тооцож төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 03/13 дугаар тогтоолоор сумдад олгох орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2017 оны орлогын шилжүүлэгийг 655628.6 мянган төгрөгөөр баталж, 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 04/04 дугаар тогтоолоор нийт орлогын шилжүүлгийн дүнг 88111.7 мянган төгрөгөөр буурлан тодотгон дараах байдлаар сумдуудад хуваарилахаар төлөвлөжээ.

*Сумдын ОНХС-д олгохоор тооцсон шилжүүлэг*

*/мянган.төг/*

№	Нийтийн нийт орлогын шилжүүлэгийн төсөв	2016.12.05-ны 03/13 дугаар тогтоолоор баталсан төсөв	2017.05.12 04/04 дугаар тогтоолоор тодотгосон төсөв	Тодотголоор хасагдсан, нэмэгдсэн дүн	
				Мөнгөн дүн	Хувиар
1	ААВИ-ААӨ	61,413.00	47,232.60	14,180.40	23.09
2	ААВІООД	15,833.80	11,433.50	4,400.30	27.79
3	АОАӨ	26,117.30	10,129.40	15,987.90	61.22
4	АОЕААІ	182,711.90	66,415.00	116,296.90	63.65
5	АДҮАОАІААЕ	79,218.20	42,275.40	36,942.80	46.63
6	АОДААІАОЕАА	15,997.50	44,797.80	(28,800.30)	(180.03)
7	ААӨЕІХЕЕҮІ	62,269.70	13,848.40	48,421.30	77.76
8	ІІАА	13,387.00	43,124.80	(29,737.80)	(222.14)
9	ІДОІІ	13,159.70	43,950.50	(30,790.80)	(233.98)
10	ДАААІО	15,478.50	44,237.30	(28,758.80)	(185.80)
11	НАЭОАІ	18,513.00	13,932.80	4,580.20	24.74
12	НҮҮҮІАҮ	42,401.30	52,701.90	(10,300.60)	(24.29)
13	ОҮӨЕА	55,963.80	26,859.70	29,104.10	52.01
14	ОАААЕ	14,287.80	45,972.30	(31,684.50)	(221.76)
15	ОЕӨЕА-АІАД	17,142.40	38,871.80	(21,729.40)	(126.76)
16	ОООАА-АІАД	21,733.70	21,733.70	-	
		655,628.60	567,516.90	88,111.70	

Аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс нь ОНХС-гаас сумдад олгох орлогын шилжүүлгийг орон нутгийн хөгжлийн эх үүсвэрт өөрчлөлт орж ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын тухайн орон нутагт хуваарилах заалтыг 2020 он хүртэл хойшлуулснаар ОНХС-гийн шилжүүлэг 553.7 сая төгрөгөөр буурсан, тогтвортой амжиргаа төсөл, хөтөлбөрөөс 10 сум урамшуулал авах болсондой холбогдуулан төсөвт тодотгол оруулан өөрчилөн Төсвийн тухай хуулийн 59.2, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолын “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон олгох шилжүүлэг тооцох” аргачлалын дагуу тооцон төлөвлөсөн байна.

#### **1.1.2.2 Аймаг сумын ОНХС-гийн эх үүсвэрийг 2 эх үүсвэрээр бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.**

Төсвийн тухай хуулийн 60.2 дахь заалтад ОНХС-гийн эх үүсвэрийг 7 төрлийн орлогоос бүрдэхээр зааснаас орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг 1744.6, хөдөөгийн ядуурлыг бууруулах төслийн урамшуулал 321.6 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн тухай хуулийн 60.2.6, 60.2.7-д заасан орлогын эх үүсвэрийг 2020 он хүртэл хойшлуулснаас 2 төрлийн орлогын эх үүсвэрийг төлөвлөөгүй, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

#### **1.1.2.1 Аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлсөн эх үүсвэрийн дагуу бүрдүүлсэн байна.**

Аймгийн ОНХС-д ОНХС-гаас олгох шилжүүлэгээр 573.8, оны эхний үлдэгдэл 80.6, аймгийн орон нутгийн төсвөөс 361.6 сая төгрөгөөр эх үүсвэрийг нэмэгдүүлж нийт 1081.8 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдэжээ.

Сумдын ОНХС-д аймгийн ОНХС-гаас олгосон 245.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс гадна өмнөх оны үлдэгдлээс 634.0 сая төгрөг, тогтвортой амьжиргаа төлсийн урамшуулал 321.6 сая төгрөг, аж ахуй нэгж байгууллага иргэний хандив 33.0, бусад эх үүсвэрээс 202.9 нийт 804.0 сая төгрөгийн орлого бүрдсэн байна.

**ОНХС-ийн орлогын эх үүсвэрийн бүрдүүлэлт**

/сая.төг/

№	Нийтийн ийдэй	Өмнөх оны үлдэгдэл	ОНХС- зас олгох шилжүүлэг	Олон улсын төсөл, хөтөлбөрөө с олгосон урамшуула л	Орон нутгийн төсвөөс	Аж ахуй нэгж байгуу лагын хандив	Бусад эх үүсвэр	Нийт эх үүсвэр
1	Аймаг	80687.9	573844.7		427267.4			1081800.0
2	Сумд	634000.0	245933.5	321583.4		33000.0	202940.0	1437457.0
	Нийт дүн	714687.9	819778.2	321583.4	427267.4	33000.0	208940.0	2519257.0

2017 онд сумдууд ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг 3 төрлийн эх үүсвэрээс бүрдүүлжээ. Үүнд: Сэлэнгэ сум татварын хувь хэмжээг нэмэгдүүлж 201.5 сая, Бүрэгхангай сум аж ахуй нэгж байгууллагын хандиваар 33.0, Баян-Ага сум 0.34 тендерийн баримт бичгийн үнэ, Гурванбулаг сум бусад эх үүсвэрээс 1.1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

#### **1.1.3.1. Аймагт ОНХС-аас олгосон шилжүүлгийг тооцох боломжгүй байна.**

#### **1.1.3.2. Аймаг ОНХС-гаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг төсвийн тухай хуулийн 59.2-т заасны дагуу хуваарилсан байна.**

Аймаг нь ОНХС-гаас олгосон шилжүүлгийн 60-аас доошгүй хувийг сум, ОНХС-д хуваарилдаг байсан бол Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2-т өөрчлөлт орсноор орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийг харилцан адилгүй хувь хэмжээгээр хуваарилах, итгэлцүүрээр хуваарилагдах хэсгийн 30-аас доошгүй хувийг бүх сумын ОНХС-д хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан 40:30:30 харьцаагаар тооцож 10.1-26.8 сая төгрөгийг хуулийн дагуу хуваарилсан байна.

#### **1.1.3.3. Аймгийн ОНХС-гаас олгох шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй байна.**

Аймгийн Засаг дарга аймгийн ОНХС-гаас сумдад олгох шилжүүлгийн баталсан хуваарийн дагуу 4, 5, 6 дугаар саруудад нийт 417.6 сая төгрөгийг шилжүүлэхээс 6 сард 67.0 сая төгрөг, 7, 8, 9 саруудад нийт 149.8 сая төгрөгийг шилжүүлэхээс 10 сард үлдэгдэл санхүүжилтийг шилжүүлсэн байна.

#### **1.2.1.1. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажил нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.**

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн заавар”-ын 2.2, 4.9 дэх заалтуудын дагуу ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг орон нутгийн хөгжлийн талаар баримталж байгаа бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байх шаардлага тавьсаны дагуу аймгийн хэмжээнд нийт 168 төсөл арга хэмжээнд 2290.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд аудитад хамрагдсан аймаг, 8 сум, 1 тосгоны орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ, хөрөнгө оруулалт нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

#### **1.2.1.2. Тухайн жилд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авч урьдчилсан саналын жагсаалт боловсруулж байгаа боловч зарим сумдын хувьд энэ ажил хангалтгүй байна.**

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 12 зүйлд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл

арга хэмжээг төлөвлөхөд аймагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санал авах тоотыг сумдад хүргүүлж санал асуулгын хуудсаар саналыг авсан байна.

Сумдын хувьд урьдчилсан санал асуулгын хуудсаар саналыг авч санал асуулгын жагсаалтыг боловсруулан ИНХ-аар хэлэлцүүлэн ЗДТГ-т хүргүүлэн ажилласан ч зарим сумдын иргэдээс санал авсан нотлох баримт байхгүй байна. Тухайлбал: Могод, Баяннуур сум нь саналыг нэгтгэсэн гэсэн тайлбар өгч байгаа боловч иргэдээс авсан асуулгын анхан шатны нотлох баримт байхгүй, Хишиг-Өндөр сум 4, 5 дугаар багийн Засаг дарга багийн иргэдээс санал аваагүй байна.

#### **1.2.1.3. Аймаг, сум иргэдээс санал аваагүй ажлыг ОНХС-гаас хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөн аймаг, сумын ИТХ-аар батлуулсан байна.**

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 2017 онд 1081.8 сая төгрөгийн нийт өртөгтэй 12 төсөл, хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу 10 төсөл арга хэмжээг сумдаас ирүүлсэн иргэдийн санал асуулгын дүнг эрэмбэлж баталгаажуулан аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн байна. Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.2-д заасан заалтыг зөрчин иргэдээс санал аваагүй Хөдөө аж ахуй, дэд, бүтэц, нийгмийн салбарын цаг үеийн шинжтэй зайлшгүй хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд 100.0 сая, Дашинчилэн сумын бүрэн дунд сургуулийн барилгын дээврийн зардал 20.8 сая төгрөгийн 2 ажлыг төлөвлөсөн нь нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсэн арга хэмжээний 16.6 хувийг эзэлж байна.

Харин аудитад хамрагдсан 8 сум, 1 тосгоны хувьд Могод сумаас бусад сумд тухайн жилд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө дээрх хуулийн заалтын дагуу төлөвлөн хэвшсэн байна. Могод сум нь тайлант онд тодотголоор нийт 15 ажил төлөвлөснөөс 13 ажлын нийт 49.7 сая төгрөгийг сумдын иргэдээс санал авалгүйгээр төлөвлөсөн байна.

#### **1.2.1.4. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөр хийгдэхээр төлөвлөсөн ажлын ТЭЗҮ, зураг төсөв нь тодорхойгүй 6 ажлыг 1 төсөвт өртөгтэй ажил болгон баталсан байна.**

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнээс 100000.0 мянган төгрөгийн өртөгтэй 1 ажил буюу хөдөө аж ахуй, дэд бүтэц, нийгмийн салбарын цаг үеийн шинжтэй зайлшгүй хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж тухайн хөрөнгийг хэдэн төсөл арга хэмжээнд зарцуулах, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөвтэй эсэх нь тодорхойгүй бөөн дүнгээр ИТХ-аар батлуулсан нь Төсвийн тухай хуулийн 29.4, "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 4.7-д "Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагауй байна.

Сумдын хувьд хөгжлийн бодлогын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудад төсөвт өртгийг тооцохгүй бөөн дүнгээр тусгаж баталдаг нийтлэг зөрчил байсаар байна. Тухайлбал: Булган суманд 4 тоглоомын тайлбайг 10.0, Баяннуур суманд Халуун усны засварын ажил 3.3, гудамж хорооллын хаягжуулалт 2.0, Сэлэнгэ суманд 2,-4-р багийн халуун усны байр барих 2.7, Хангал суманд мал угаалгын ванн барих 1,8 сая төгрөг гэх мэт төлөвлөж байгаа нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” -ын 12.2.2 а, б, в, г, 22-д заасан “Хөтөлбөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн нийт өртөг” зэрэг үзүүлэлтүүдийг тодорхой тооцоолж тусгаагүй нотлох баримтгүй, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд төсөвт өртөг, үр ашиг, үр өгөөж нь тодорхойгүй байна.

#### **1.2.2.1. Аймаг 50.0 сая төгрөгийн өртөгтэй өвсний фонд бэлтгэх ажилд тендер зарлаагүй шууд гэрээ байгуулсан байна.**

ОНХС-гийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлсэн 122 төсөл арга хэмжээний 2300.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээний сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зарлаж сонгон шалгаруулсан байна.

*Булган аймгийн ОНХС-ийн хөрөнгийн тендер худалдан авах ажиллагаа,  
сонгон шалгаруулалт*

/сая.төг/

№	Аймаг, сумын нэр	ХАА-ны журам							
		НТШ		Хязгаарлагдмал		ХА		ШУУД	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг ОНХС	1	314.8			2	64	9	703
2	Сумд ОНХС	9	448.6	1	20.3	25	233.3	102	516.9
3	Нийт дүн	10	763.4	1	20.3	27	297.3	111	1219.9

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Өвсний фонд байгуулах ажилд тендер зарлаагүй аймгийн Нөөцийн газартай шууд гэрээ байгуулан санхүүжүүлсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2-д “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш өртөгтэй бараа ажил үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.4-д “Тендер шалгаруулалтын журмыг сонгоходоо тухайн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртөгийг үндэслэл болгоно” гэж заасныг зөрчжээ.

Цаашид төсөл, хөтөлбөр арга хэмжээг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтыг мөрдөн ажиллах, дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аймаг, сумдын үнэлгээний хорооны гишүүд гүйцэтгэгчийг сонгоходоо Сангийн сайдын баталсан тендерийн жишиг баримтын дагуу боловсруулан хөтөлж, ажлын

хэсэг болон үнэлгээний хорооноос гаргасан зөвлөмжийг үндэслэн ажил болон бараа үйлчилгээ нийлүүлэгчтэй гэрээ байгуулан ажилласан байна.

**1.2.2.2. Сумд ОНХС-гаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбарийн хэрэгжилтэнд Засаг даргын захирамжаар томилогдсон мэргэжлийн бус захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна.**

Сангийн Сайдын 2012 оны 290 тушаалын 4 дүгээр зүйлд заасны дагуу аймагт хэрэгжиж буй төсөл арга хэмжээд ГХБХБГ-аас хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж гэрээний заалтын дагуу санхүүжилтийг олгосон байна.

Харин сумдын тухайд Засаг даргын захирамжаар байгуулагдсан мэргэжлийн бус хүмүүс захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа нь ажил чанартгүй, дутууг хийгдэх эрсдлийг дагуулж байна. Тухайлбал:

Гурванбулаг сумын төвд хяналтын камер суурилуулах ажлыг гүйцэтгэх гэрээг “Эрхэм Хилэнц эрдэнэ” ХХК-тай байгуулан ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авсан, сумын соёлын төвийн талбай, сумын төвийн соёл спортын талбайг тохижуулах ажлыг гүйцэтгэх гэрээг “Өрнөх хийморь” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлэн хүлээлгэн өгсөн байна.

Дээрх ажлуудад захиалагчийн хяналтыг мөн хүлээн авахдаа мэргэжлийн байгууллагыг оролцуулаагүй, камер суурилуулах ажлыг захиалагчийн хяналтын зардал 665.5, спортын тайлбайг тохижуулах ажлын захиалагчийн хяналтын зардал 1001.1 нийт 1666.8 мянган төгрөгийг суутган авч холбогдох байгууллагад шилжүүлээгүй зөрчилд төлбөрийн акт бичлээ.

Могод сумын 3000.0 мянган төгрөгөөр хийгдсэн замын тэмдэг тэмдэглээний ажилд захиалагчийн хяналтыг хийгээгүйгээс одоог хүртэл гүйцэтгэсэн ажлыг хүлээж аваагүй, замын тэмдэг тэмдэглэгээний ажлын гүйцэтгэлд санхүүжилтийг олгосон байна.

**1.2.2.3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд нийцэхгүй, урсгал зардалд зарцуулсан байна.**

Сумдын орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний зарцуулалтыг хуулийн заалттай нийцүүлэн авч үзвэл дараах сумд Төсвийн тухай хуулийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1-д “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга, хэмжээ”гэсэн заалтыг зөрчиж 10 төсөл арга хэмжээнд нийт 42.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

- Баян-Агт сум олон нийтийн цагдаа ажиллуулж цалингийн зардалд 4.0,
- Булган сум цагдаагийн бэлэн бус тorgуулын машин худалдан авч 2.5,
- Могод сум олон нийтийн цагдаагийн хувцас, цалингийн зардалд 1.3, нийтийн хогийн цэгийн сахиул цалингийн зардалд 1.0 ,
- Сайхан сум хүндэтгэлийн гэр худалдан авах, Байгаль орчинь хяналтын пост ажилуулах зэрэгт 18.0 ,
- Сэлэнгэ сум интернэт холболт шилэн кабель суурилуулалтын санхүүжилтийн дутуу 5.9
- Хангат сум цагдаагийн бэлэн бус тorgуулын машин худалдан авч 2.5,

- Тэшиг сум цагдаагийн албан хэрэгцээнд бэлэн бус торгуулийн машин, драйгер, компьютер, принтер худалдан авхад 5.2 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зориултын дагуу зарцуулаагүй сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга, холбогдах албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллах зөвлөмжийг хүргүүлж ажиллаа.

#### **1.2.2.4. Аймгийн хэмжээнд нийт 370.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.**

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр 2017 онд хийж дууссан нийт 817.2 сая төгрөгийн 109 төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгахаас 446.7 мянган төгрөгийн 56 ажил буюу 48.6 хувийг бүртгэл тайланд тусгасан байна. Нийт 370.5 мянган төгрөгийн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9.1, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” – ын 8.6-д заасны дагуу бүртгэл тайланд тусгаагүй байна. Үүнийг аймаг, sumaар хүснэгтээр харуулбал:

Нэрс	Бүртгэх төсөл арга хэмжээ		Бүртгэлд тусгасан төсөл, арга хэмжээ		Бүртгэлд тусгагдаагүй төсөл, арга хэмжээ	
	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг
Булган аймаг	7	543.7	4	222.0	3	321.7
16 сум 1 тосгон	102	273.5	49	224.7	4	48.9
нийт	109	817.2	53	446.7	7	370.5

Хүснэгтээс төсвийн хөрөнгийг зарцуулсан боловч данс бүртгэлд тусгаж ажилаагүй байгаа нь хөрөнгө эзгүйдэх, устгах, шамшигдуулж болзошгүй эрсдэлтэй байна. Иймд дээрх бүртгэлд тайланд тусгаагүй хөрөнгийг данс бүртгэлд тусгах албан шаардлага хүргүүллээ.

#### **1.3.1.1. Сумдын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд ОНХС-гийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж ажиллаагүй байна.**

Аймгийн ИТХ-ын 2018 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөх талаар аймаг, сумын ИТХ-үүд Иргэний танхимдаа хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. Аймгийн ИТХ төсвийн ерөнхийлөн захирагчийн улирлын төсвийн гүйцэтгэлийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсэн боловч Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 9.4-д “Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын идэвхтэн иргэд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-гаас хэрэгжсэн хөтөлбөр төсөл арга хэмжээний үр дүнд хяналт тавьж үнэлгээ хийнэ” гэж заасны дагуу хэрэгжсэн төсөл хөтөлбөр арга хэмжээний үр дүнд хяналт тавьж үнэлгээ хийсэн талаар баримт материал дутуу, аудитад хамрагдсан 8 сум, 1 тосгоноос Гурванбулаг, Баяннуур сумаас бусад сумдын ИТХ дэргэдээ хяналтын хороо байгуулаагүй байгаагаас дүгнэхэд тухайн заалт бүрэн хэрэгжээгүй байна.

**1.3.1.2.** Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 9.2-дахь заалтад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалтыг хэрэгжүүлэхээр тусгажээ.

Дээрх чиг үүргийн биелэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтанаас тодруулхад хяналт шалгалт хийгдээгүй байна.

**1.3.2.1.Сумын ОНХС-ийн хэрэгжилтийн явцын тайланд дүгнэлт дүн шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлээгүй байна.**

Аймгийн Засаг дарга ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх үүрэн бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулаагүй, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөөгүй, цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг сум бүрээр гаргаагүй, үр дүнгийн тайланг Сангийн Яамны Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангийн хэлтэст хүргүүлээгүй нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.2-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

**1.3.2.2.Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх дээ “Шилэн дасны тухай” хуулийн шаардлагыг хангаж ажилласан байна.**

Аймгийн нэгдсэн веб хуудсанд ОНХС-гийн жилийн батлагдсан төсөв, төсвийн тодотгол, хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний жагсаалт, төсөвт өртөг зэргийг тухай бүр мэдээлсэн байна.

Аймгийн нэгдсэн веб хуудсанд сум бүр цэстэй ба сумын ОНХС-гийн батлагдсан төсөв, тодотгол, хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний жагсаалт, төсөвт өртөг, тендерийн урилга, ОНХС-гийн гүйцэтгэл, хийгдсэн ажлын тайлан зэргийг байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.2.2-т “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мөнгөн болон бусад гүйлгээг хамруулахаар заасны дагуу ОНХС-гийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг мэдээлж байна.

**1.4. Төсвийн тухай хуулийн 60.3.3-д “Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал ” гэсэн заалтыг үнэдслэн сумд ОНХС-гийн хөрөнгөөс баяр наадмын зардалд 7.0-20.0 сая төгрөгийг зарцуулж байгаа нь Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 271 дүгээр тогтоол, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.5-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас тогтоосон үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоосон заалттай нийцэхгүй байна. Иймд ОНХС-ийн заавар журамд наадмын зардалд зарцуулах дээд, доод хязгаарыг тогтоож өгөх шаардлагатай байна.**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг олон нийтийн цагдаагийн цалингийн зардал, цагдаагийн хувцас, цагдаагийн бэлэн бус торгуулийн машин, цагдаагийн

драйгер, компьютер, принтэр, гэрэлтүүлгийн цахилгааны зардал, хогийн цэгийн манаачийн зардал гэх мэт урсгал зардал зарцуулсан зөрчил давтагдсаар байгаа нь сангийн үйл ажиллагаа зорилого зорилтоддоо хүрэхгүй байх эрсдэлийг бий болгож байна.

### **Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл:**

Нийцлийн аудитаар нийт 337 иргэдийг хамруулсан санал асуулганд хамруулсан. Санал асууллагт орсон хүмүүсийн дундаж наслалт 37 байна. Судалгаанд оролцсон хүмүүсийн боловсролын түвшингээр дээд 186, дунд 50, бүрэн дунд 87 нийт 323 хүн бүртгүүлсэн байна.

Санал асуулгын маягтаас орон нутгийн хөгжлийн сангийн талаархэр мэдээлэлтэй вэ? гэсэн асуултанд 193 хүн хангалттай, 134 хүн хангалтгүй гэж хариулсан байна. Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ? Гэсэн асуултанд хангалттай сайн 133, хангалтгүй 76, сайн мэдэхгүй 121 иргэн тус тус хариулсан байна.

Аудитын санал асуулгад хамрагдсан 337 иргэний санал асуулгын маягтаас үзэхэд ОНХС-гийн талаар авах мэдээлэл, TAX тавих хяналт сул байгааг илэрхийлж байна.

**Булган аймаг дахь Төрийн  
Аудитын газар**

**Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт  
болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр  
дүнтэй зохион байгуулсан уу?**

**Бүлэг II**      **Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн төлөлт хугацаа хэтэрч, ажлын  
байр бодитой үр дүн хангалтгүй байна.**

#### **2.1.1. Сум хөгжүүлэх сангийн орлогын эх үүсвэрийн төлөвлөлт хангалтгүй байна.**

Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлagnaх, хяналт тавих журам”-ын 2 дахь заалтад сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг 4 эх үүсвэрээс бүрдүүлэхээр заажээ.

Аймгийн хэмжээнд 2017 онд сум хөгжүүлэх санд улсын болон орон нутгийн төсвөөс олгосон эргэлтийн хөрөнгө, гадаад улс, ОУ-ын байгууллага түүнчлэн гадаад дотоодын аж ахуй нэгж иргэнээс өгсөн буцалтгүй тусламж хандиваас орлогын эх үүсвэр бүрдээгүй байна.

Иргэн аж ахуйн нэгжид сангаас олгосон зээлийн хүүгийн орлогын эх үүсвэрийг нийт 16 sumaас 37.5 хувь нь төлөвлөсөн, сумдын 62.5 хувь нь тухайн онд эргэн төлөгдөх зээл, зээлийн хүүг бөөн дүнгээр төлөвлөдөг мөн алдангийн орлогыг огт төлөвлөхгүй байгаа нь “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлagnaх, хяналт тавих журам”-ын 1.8, 2 3.5.7-д заасан заалттай бүрэн нийцэхгүй байна.

Сум хөгжүүлэх сангийн 2017 оны сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг  
хүснэгтээр харуулбал

Д/д	Сумдын нэрс	Сум хөгжүүлэх сангийн эхний үлдэгдэл	Иргэн аж ахуйн нэгжид сангаас олгосон зээлийн хүүгийн орлого	Эргэн төлөгдсөн зээл, үндсэн төлбөр	Алдан ги	Нийт		Нийт эх үүсвэр	
						Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Баян-Агт	44.8	5.7	7.2	35.07		5.7	42.2	87.0
2	Баяннуур	2.2			14.3		0.0	14.3	16.5
3	Бугат	13.1			36.5		0.0	36.5	49.6
4	Булган	47.2		16.1	206.5	9.57	0.0	232.17	279.4
5	Бүрэгхангай	2.79		0.8	45.1		0.0	45.9	48.7
6	Гурванбулаг	50.1	5.2	5.5	42.6	1.3	5.2	49.3	99.4
7	Дашинчилэн	6.2	8.9	7.6	54.5	0.3	8.9	62.4	68.6
8	Могод	7.8	3.2	2.9	54		3.2	56.9	64.7
9	Орхон	21.8			6.9		0.0	6.9	28.6
10	Рашаант	3.1			65.9	1.3	0.0	67.2	70.3
11	Сайхан	21.9	2.1	2.1	67.8	0	2.1	69.9	91.8
12	Сэлэнгэ	96.4		0.2	15.3		0.0	15.5	111.9
13	Тэшиг	13.4			11.5		0.0	11.5	24.9
14	Хангал	13.3		6.4	69.2		0.0	75.6	88.9
15	Хишиг-Өндөр	25.1	4.6	3.4	63.6		4.6	67	92.1
16	Хутаг-Өндөр	3.5		3.8	58.3		0.0	62.1	65.5
<b>Аймгийн нийт дүн</b>		<b>372.7</b>	<b>29.8</b>	<b>55.9</b>	<b>846.98</b>	<b>12.4</b>	<b>29.8</b>	<b>915.4</b>	<b>1288.0</b>

Баян-Агт, Бүрэгхангай, Рашаант сумдаас бусад сумын сум хөгжүүлэх сангийн дансанд баг хөгжүүлэх сан, ЖДҮ дэмжих сан, гамшигаас хамгаалах сан, нөөцийн махны хөрөнгийн эх үүсвэр гэх мэт сангийн хөрөнгө цуг байршиж байгаа нь “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах , хяналт тавих журам”-ын 1.4-д “Энэ журмын 1.3-т заасан дансанд сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө байршуулахыг хориглоно” гэж заасан заалттай нийцэхгүй байна. Иймд сум хөгжүүлэх сангийн дансанд байршиж байгаа өөр бусад сангийн хөрөнгийг сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс тусд нь данс нээж байршуулах зөвлөмжийг хүргүүллээ.

Сумдын сум хөгжүүлэх сангийн дансанд байршиж байгаа бусад сангийн хөрөнгийн үлдлэгдлийн судалгаа

/сая.төг/

Сум хөгжүүлэх сангийн дансанд байршиж байгаа хөрөнгийн жагсаалт /2017.12.31-ний байдлаарх эцсийн үлдэгдэл/	Баяннуур	Бугат	Булган	Гурванбулаг	Дашинчилэн	Могод	Орхон	Сайхан	Сэлэнгэ	Тэшиг	Хангал	Хишиг-Өндөр	Хутаг-Өндөр
Баг хөгжүүлэх сан	1.0	0.4	5.2	1.4	4.1	8.2	5.1	0.0	2.9	0.4	0.0	7.4	4.7
ЖДҮ дэмжих сан				0.6	11.8								
Гамшигаас хамгаалах сан				29.1									
Өөр бусад сан			100.0						1.8				
Нийт дүн	1.0	0.4	105.2	31.1	15.9	8.2	5.1	0.0	4.7	0.4	0.0	7.4	4.7

**2.1.2 Сум хөгжүүлэх сангаас 2017 онд олгосон зээлийн гэрээний дагуу үндсэн төлбөр, хүүг бүрэн төвлөрүүлээгүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлд алданги огт тооцоогүй байна.**

Булган аймгийн хэмжээнд 2017 онд сум хөгжүүлэх сангаас 10 сум нийт 121 төсөлд 656.3 сая төгрөгийн зээл олгожээ.

*2017 онд олгосон зээлийн эргэн төлөлтийн судалгааг хүснэгтээр харуулбал:  
/сая.төг/*

№	Аймаг, сумын нэр	2017 оны зээл олголт			2017 онд олгосон зээлийн эргэн төлөлт		
		Зээлдэгчийн тоо	Зээлийн хэмжээ	2017 онд төлөх нийт дүн	Хугацаа хэтрэлттэй авлагын дүн	Хугацаа хэтрэлтийн хувь	
1	Баян-Агт	19	74.4	1.0	0.8	72.9	
2	Булган	34	263.5	97.2	44.9	46.2	
3	Могод	5	42.0	1.00	0.63	63.0	
4	Рашаант	13	65	2.2	0.5	22.7	
5	Сайхан	14	49.5	0.87	0	0.0	
6	Хангал	14	55.0	1.48	1.48	100.0	
7	Хишиг-Өндөр	6	52.0	6.5	4.9	75.4	
8	Хутаг-Өндөр	8	49.5	0.8	0.3	37.5	
	Аймгийн нийт дүн	113	650.9	111.1	53.5	48.1	

2017 онд олгосон зээлийн эргэн төлөлтийг судлан үзэхэд 113 зээлдэгчийн 53.5 сая төгрөгийн буюу зээлийн 48.1 хувь нь хугацаа хэтрэлттэй, хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлтөнд алданги тооцоогүй байгаа нь “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлгагнах , хяналт тавих журам”-ын 3.5.5-д заасан

заалтыг сумдын Засаг дарга нар бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, иргэн, хуулийн этгээд нь 4.7-д заасан заалтыг зөрчсөн байна.

Аудитад хамрагдсан сумдын 2017 онд олгосон зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн хугацаандаа төлөөгүй 54.8 сая төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүү, 10.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.5 хувийн алданги тооцон нийт 65.4 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн орон нутгийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Мөн Гурванбулаг, Могоод сумын өмнөх онд олгосон зээлийн 2017 онд төлөх хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлтийг төлөөгүй 38.3 сая төгрөгийн үндсэн төлбөр, зээлийн хүүнд, 8.6 сая төгрөгийн алданги, Хангал, Сэлэнгэ сумын өмнөх онуудын хугацаандаа төлөөгүй нийт 28 зээлдэгчийн 40.5 нийт 87.4 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн орон нутгийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

### **2.2.1. Сум хөгжүүлэх сангаас зээл хүссэн иргэн, хуулийн этгээдийн боловсруулсан төсөл сонгон шалгаруулхад журмын 4.2.3, 4.2.4, 4.3.5-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг хянан шийдвэрлээгүй байна.**

Аймгийн хэмжээнд 8 сум СХС-гаас зээл олгожээ. Аудитад хамрагдсан сумдаас 2017 онд Булган, Могоод, Хишиг-Өндөр сумдууд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.11-д заасны дагуу сумын ИТХ-аар тогтоосон байна.

Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг байгуулан сумын засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн төслийг “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.1-4.4-д заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, хэлэлцэж шийдвэрлэж байгаа боловч журмын зарим заалт бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал:

- Сонгон шалгаруулсан төслийг түүвэрлэн үзэхэд гэрээний хугацаанд зээлийг эргэн төлөх боломжтой байх, жижиг, дунд үйлдвэр эрхлэх талаар зохих мэдлэг, туршлагатай байх шалгуурын нотлох баримт байхгүй,
- Төсөлд төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдлийг бодитой тодорхойлоогүй, түүнийг даван туулах арга замыг тусгаагүй,
- Барьцаа хөрөнгийн гэрээг байгуулж байгаа боловч зарим төслийн барьцаа хөрөнгийн эх хувь байхгүй зэрэг нийтлэг зөрчил илэрч байна,
- Булган сум 2017 онд олгосон 2 зээлдэгчийн төсөл, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, барьцаа хөрөнгийн гэрээ, барьцаа хөрөнгийн эх хувь гэх мэт зээлдэгчийн хувийн хэрэг байхгүй зөрчил илэрсэн.

### **2.2.2. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн гэрээг зорих журмын дагуу байгуулж байгаа боловч гэрээнд заасны дагуу зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь төлөхгүй байна.**

Сумын Засаг дарга төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй зээлийн болон барьцааны гэрээ байгуулж зээлийн хөрөнгийг төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн дансанд журмын дагуу шилжүүлж, зээлдэгчийн талаарх холбогдох баримт бичгүүдийг эх хувиар нь баримтжуулан хадгалж байгаа боловч журмын 4.8.9, 4.9-д заасан төслийн сонгон шалгаруулах шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг баталгаажуулсан баримт бичиг, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх бусад мэдээллийг баримтжуулаагүй байна.

Аудитын судалгаагаар хугацаа хоцорсон зээл, зээлийн хүү нийт зээлийн 52.2 хувийг эзэлж байгаа нь Сум хөгжүүлэх сангийн журмын 4.7-д “Иргэн хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүгийн хүүгээрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” заасан заалтыг иргэд мөрдөхгүй зээлийн эргэн төлөлт хангалтгүй, төлөлтийг цаг тухайд нь шаардаж төлүүлж байгаагүйтэй холбоотой байна. Энэ нь цаашид сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн эргэлт хангалтгүй, дараагийн төслийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх эрсдлийг дагуулж байна.

### **2.2.3. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх, ажлын байр төслийн үр дүнд нэмэгдсэн ажлын байрыг баталгаажуулаагүй байна.**

Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлттэй зээл олгоход зарцуулна гэсний дагуу зориулалтаар нь зарцуулсан иргэд байгаа хэдий ч, зээлийг аваад төсөл хэрэгжээгүй, өөрийн хөрөнгө дутагдалтайгаас үйл ажиллагаа зогсонги байдалтай болж зээл төлөх чадваргүй, хугацаа хэтэрсэн зээлдэгчид дийлэнх хувийг эзэлж байна.

Аудитын явцад төсөл хэрэгжүүлж буй иргэдийн үйл ажиллагаатай танилцахад үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр зээл авсан иргэдийн үйл ажиллагаа хэрхэн өргөжсөн, зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг тодорхойлох, дүгнэлт өгөх боломжгүйгээс гадна төсөл хэрэгжүүлэхээр санал болгосон зээлийн хэмжээг бичигдсэн төслийн 50 хувиар /дундажаар/ олгож байгаа нь төслийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр дутагдаж зээлийг зориулалт бусаар зарцуулах эрсдлийг нэмэгдүүлж байна. Тухайлбал:

- Булган сумын сум хөгжүүлэх сангаас иргэн Д.Гантулга ажил үйлчилгээгээ өргөтгөж шинээр ажилгүй 3 иргэнийг ажлын байраар хангах, шинэ тоног төхөөрөмж авах төсөлд өөрийн хөрөнгөөр 25.0 сая, төслийн санхүүжилтээр 50.0 сая төгрөгийн зээл хүсэхэд 5.0 сая төгрөг олгосон нь төслийн хөрөнгө хүрэлцээгүй, тоног төхөөрөмж эвдэrsэн гэсэн шалтгаанаар үйл ажиллагаа өргөжөөгүй, ажлын байр бий болоогүй,
- Булган сумын 5 дугаар багийн иргэн Б.Баттулга нь үр тариа, төмс хүнсний ногооны төрөлжсөн агуулах барих 20.0 сая төгрөгийн төсөлд 10.0 сая төгрөгийн зээл олгосон нь тухайн төслийн хөрөнгө хүрэлцээгүй гэсэн шалтгаанаар одоог хүртэл хэрэгжээгүй,
- Булган сумын 6 дугаар багийн иргэн С.Хүрэлтулга нь “Булган брэнд-арьс, шир, суран эдлэл” төсөлд 8 сая төгрөгийн зээл авсан, үйл ажиллагаатай нь

танилцахаар очиход нүүсэн, сум хөгжүүлэх сангийн мэргэжилтэн хаашаа нүүсэн талаар мэдээлэлгүй байсан.

- Булган сумын 3 дугаар иргэн Б.Батсүх нь дугуй засвар, гагнуурын төслөөр 5.0 сая төгрөгийн зээл авсан боловч үйл ажиллагаа эрхэлдэг нь тодорхой бус зэрэг зөрчлүүд байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлagnaх, хяналт тавих журам”-ын 1.8-д “Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулан” гэж заажээ. Тухайн заалтын дагуу аудитад хамрагдсан сумд үйл ажиллагааны зардалд Бугат сум 70.5, Булган сум 11162.8, Гурванбулаг сум 238.9, Могод сум 220.0, Сэлэнгэ сум 2560.0, Хангал сум 82.9, Хишиг-Өндөр сум 442.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Сумдын сангийн хөрөнгөөс үйл ажиллагааны зардалд зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлийг шалгахад Булган сум зээлийн хүүгийн орлогын журмын 1.8-д заасны дагуу боловсруулаагүй эргэн төлөгдөх зээлийн дүн, хүүгийн орлогыг бөөн дүнгээр төлөвлөн ИТХ-аар батлуулсан байна. Булган сумын 2017 оны зээлийн хүүгийн орлогыг тооцон, зардлын гүйцэтгэлийг үзэхэд 2017 онд зээлийн хуваарийн дагуу хүүгийн орлого 10282.4 мянган төгрөг эргэн төлөгдөхөөс журмын дагуу хүүгийн орлогын 50 хувь 5141.2 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулахаар байхад үйл ажиллагааны зардалд 11162.8 мянган төгрөгийг зарцуулан журмын 1.8-д заасан заалтыг зөрчсөн. Мөн журмын 1.9-д заасан заалтыг зөрчин сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн гэсэн орон тоо шинээр бий болгон цалинжуулан ур чавдарын нэмэгдэлд 1196.9, ажилтны байгууллагаас төлөх НДШ-д 872.2, үр дүнгийн урамшуулалд 216.9 нийт 2286.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн актыг тогтоолоо.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлagnaх, хяналт тавих журам”-ын 4.3.6-д “ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байна” гэж заасан шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч нар нь төсөлд ажлын байрыг нэмэгдүүлнэ, НДШ төлнө гэх зэргээр төсөлд тусгасан боловч аудитад хамрагдсан сумдын хувьд сангаас төсөл хэрэгжүүлсэн үр дүнд бий болсон баталгаат ажлын байр нэмэгдсэн нь тодорхой бус, НДШ төлсөн баримт байхгүй байгаа зэрэг нь төсөл хэрэгжүүлснээр ажлын байр нэмэгдсэн эсэх нь эргэлзээтэй байна.

### **2.3.1. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд тавих хяналт сул байна.**

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлagnaх, хяналт тавих журам”-ын 3.3-д Сангийн үйл ажиллагааны талаар сумын ИТХ-ын хэрэгжүүлэх чиг үүргийг заасан. Аудитад хамрагдсан сумдын ИТХ нь сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон

тооны бус зөвлөлийг байгуулсан байна. Гурванбулаг, Бугат, Хишиг-Өндөр, Баяннуур сумаас бусад сумдын зөвлөл нь зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт шалгалт хийгээгүй, сангийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байна.

Аймгийн хэмжээнд хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 1173.4 сая төгрөг, чанаргүй зээл 217.8 сая төгрөг байгаагаас дүгнэхэд сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих хяналт үр дүн хангалтгүй байна.

### **2.3.2 . Сангийн хөрөнгийн бүртгэл бодитой байна.**

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүртгэлийг зээлдэгч нэг бүрээр авсан зээлийн зориулалт, хамрагдсан огноо, зээлийн хэмжээ, хүүгийн орлогыг бүртгэж орлого, зарлагын гүйцэтгэлийг сумд ЗДТГ-ын санхүүгийн програм бааз үүсгэн бүртгэж санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр тайлагнаж жил бүрийн санхүүгийн аудитаар баталгаажуулж байна. Мөн “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5.4-д заасны дагуу сумдын сум хөгжүүлэх санг хариуцан ажиллаж байгаа ажилтан улирал жилийн тайланг аймгийн Засаг даргад хүргүүлэн ажиллаж байна.

### **2.3.3 Зээлийн эргэн төлөлтийг цаг хугацаандаа барагдуулаагүй, төсөл хөтөлбөрийг зориулалтын дагуу зарцуулаагүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хариуцлага тооцож ажиллаагүй байна.**

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс төсөл хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдийн зээлийн гэрээнд алдангийг тусгаж байгаа боловч зээлийн гэрээний дагуу хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд Гурванбулаг сум 1265.8, Дашинчилэн сум 305.0, Рашаант сум 1373.9 мянган төгрөгийн алдангийг тооцож бусад зээлийн гэрээний заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй нь “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.7-д “Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана” гэж заасан заалттай бүрэн нийцэхгүй байна.

Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу хугацаандаа барагдуулаагүй, зээлийн үлдэгдэлтэй байгаа иргэдээс 153 иргэний 702.0 сая төгрөгийн зээлийн үндсэн төлбөр, хүүг шүүхэд нэхэмжилсэн байна.

**2.4.** Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.7-д зээлдэгч зээлийг Хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд зээлийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй алданги тооцооюудаа журамд заасан нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 3-д заасан “Зээлийг заасан хугацаанд төлөөгүй бол зээлийн гэрээний үүргээ бүрэн биелүүлж дуусах хүртэл

хугацаанд зээлийн үндсэн хүү, гэрээнд заасан бол түүний хорин хувиас хэтрэхгүй хэмжээний нэмэгдүүлсэн хүү төлнө.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.2-д “Сангийн хөрөнгийг сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, шинэчлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөнгөлттэй зээл олгоход зориулан зарцуулна” гэж заасан ч сум хөгжүүлэх сангийн зээлийг олгохдоо зээлдэгчдээ жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх туршлагатай, боломжтой эсэх, ажлын байртай эсэх, үйл ажиллагаа явуулах зах зээл байгаа эсэхийг судлахгүйгээр мэдээлэлд ойр эрх мэдэлтэй хүмүүсийн танил тал гэх мэт нэгдмэл ашиг сонирхолын үндсэн дээр төслийг сонгон шалгаруулж олгосноос зээлийг зориулалт бусаар ашиглах, зээлийн эргэн төлөлт хангартгүй, дараагийн төслийг санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх, сум хөгжүүлэх сан зорилго, зорилтдоо хүрэхгүй байх эрсдэл байгааг харуулж байна.

Цаашид сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, хэрэгжилэлтэнд тавих хяналтыг сайжруулах, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын заалтыг илүү тодорхой болгох шаардлагатай байна.

#### **Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл:**

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа орон нутагт хэрхэн хэрэгждэг, иргэдэд сурталчилдаг эсэх, иргэдэд хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгждэг эсэхийг тодорхойлсон санал асуулганд 15, сум 1 тосгоны жижиг, дунд эрхэлдэг 192 иргэн судалгаанд хамрагдсан. /судалгааны нэгтгэл Хавсралт-2/

